



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 2 дугаар сарын 10-ны
өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь жижиг, дундүлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эхүүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж

2.1. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар Засгийн газар үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч болон давхар батлан даагчаар орж байгаа зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн байдал

4.1. Зээлийн батлан даалтын сан /цаашид "Сан" гэх/ нь барьцаа өрөнгийн дутагдалтай жижиг, дундүлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. “жижиг, дунд үйлдвэр эрхлэгч” гэж Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5.1-д заасан этгээдийг;

5.1.2. “батлан даалт” гэж Иргэний хуулийн 458 дугаар зүйлд заасныг;

5.1.3. “зээлийн батлан даалт” гэж Банк, ~~эрхий~~ бхуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасныг;

5.1.4. “жижиг, дундүйлдвэрийг хөгжүүлэх сан” гэж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.4.4-т заасныг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ САНГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6 дугаар зүйл. Санг үүсгэн байгуулах

6.1. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэн, хуулийн этгээд Сангийн үүсгэн байгуулагч байж болно.

6.2. Үүсгэн байгуулагчдын анхны хурлаар Сангийн дүрмийг батлах бөгөөд Сангийн дүрмийг баталснаар Санг үүсгэн байгуулсанд тооцно.

7 дугаар зүйл. Сангийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт

7.1. Сан нь удирдах ~~эвлөл~~, хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирал, зээлийн батлан даалтын хороотой байна.

7.2. Сан нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна зохион байгуулалтын бусад бүтэцтэй байхаар дүрэмдээ зааж болно.

7.3. Сангийн удирдах дээд байгууллага нь ~~Удирдах~~ байх бөгөөд үүсгэн байгуулагчдын хурлаас Сангийн дүрэмд заасны дагуу Удирдах зөвлөлийн гишүүдийг томилно.

7.4. Сангийн үүсгэн байгуулагчдын анхны хурлаас Сангийн ~~дүрмийг~~ баталж, Удирдах зөвлөлийн гишүүдийг томилсны дараа үүсгэн байгуулагчдын энэхүү эрх нь Удирдах зөвлөлд шилжих бөгөөд Сангийн дүрэмд Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.5. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь төсөв, санхүүгийн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн ~~өрийн~~ захиргааны төв байгууллага, хөрөнгө оруулагч, хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ.

7.6. Удирдах ~~эвлөлийн~~ бүрэлдэхүүнд Сангийн үйл ажиллагаатай шууд холбоотой этгээдийн төлөөллийг оруулж болно.

8 дугаар зүйл. Сангийн дүрэм

8.1. Сангийн дүрэмд дараах зүйлийг тусгана:

8.1.1. нэр, хаяг байршил;

8.1.2.зорилго;

8.1.3.үйл ажиллагааны чиглэл, зарчим;

8.1.4.удирдлага, зохион байгуулалтын үндэс, хяналтын тогтолцоо, эрххүчийг томилох, чөлөөлөх журам;

8.1.5.Удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын бусад бүтцийн эрх хэмжээ, чиг үүрэг;

8.1.6.Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гаргах журам.

8.2.Сангийн дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахад Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

9 дүгээр зүйл. Сангийн үндсэн үйл ажиллагаа

9.1.Сан нь дараах үйл ажиллагааг явуулна:

9.1.1.банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах;

9.1.2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1-д заасны дагуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээс гаргасан хаалттай өрийн бичгээс банк, санхүүгийн байгууллага худалдаж авсан бол уг худалдаж авсан өрийн бичигт батлан даалт гаргах.

9.2.Сан нь энэ хуулийн 9.1.1-д заасан батлан даалтыг гаргахдаа тухайн зээл олгох банк, санхүүгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэнэ.

9.3.Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж, харилцах хэлбэрээр болон Засгийн газрын өрийн бичиг, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад хэлбэрээр байршуулж болно.

10 дугаар зүйл. Бусад үйл ажиллагаа

10.1.Сан нь үндсэн үйл ажиллагаагаатайгаа холбогдуулж дараах бусад үйл ажиллагааг явуулна:

10.1.1.зээлийн мэдээлэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хариуцсан эрх бүхий байгууллага, шаардлагатай бусад төрийн болон хувийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, лавлагаа авах;

10.1.2.зээлийн батлан даалт болон холбогдох бусад үйл ажиллагаанаас бий болсон хугацаа хэтэрсэнэр, авлагыг барагдуулах зорилгоор тэдгээрийг бусдад худалдах, хуулиар зөвшөөрсөн бусад арга хэмжээг авах.

11 дүгээр зүйл. Сангийн үйл ажиллагааны журам

11.1. Удирдах зөвлөл Сангийн үйл ажиллагааны дараах журмыг батална:

11.1.1. батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа, хураамж, шимтгэл, бусад нөхцөл;

11.1.2. батлан даалт гаргах журам;

11.1.3. батлан даалтаар хүлээсэн үүрэг гүйцэтгэх журам;

11.1.4. батлан даалт гаргуйл ажиллагааны хүрээнд банк, санхүү гийн байгууллагатай хамтран ажиллах журам;

11.1.5. Сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам;

11.1.6. бүртгэл, мэдээллийн хадгалалтын журам.

11.2. Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.

12 дугаар зүйл. Батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамж

12.1. Сан нүйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамж авах бөгөөд батлан даалтын шимтгэл, хураамжийн хэмжээг Сан тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

13 дугаар зүйл. Засгийн газар, түүний харьяа байгууллагын оролцоо

13.1. Сангийн хүсэлтээр сангийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас Санд нэмэлт санхүүжилт, хөнгөлөлттэй зээл олгож болно.

13.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сангийн гаргасан нийт батлан даалтын 60 хүртэл хувийг давхар батлан даана.

13.3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь тухайн жилд Сангийн гаргахаар төлөвлөсөн нийт батлан даалтын дүнгийн 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг болзошгүй өр төлбөрийг нөхөхөд зориулан бэлэн мөнгө хэлбэрээр дансандаа байршуулна.

13.4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас гаргах давхар батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хөлсийг Сантай зөвшилцөж, жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ САНГИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, БҮРТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

14 дүгээр зүйл. Сангийн өөрийн хөрөнгө

14.1. Сан үйл ажиллагаагаа явуулахад хүлээх үүргийн баталгаа болгох зорилгоор өөрийн хөрөнгөтэй байна.

14.2. Сангийн өөрийн хөрөнгийн доод хэмжээг болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

14.3. Сангаас гаргах батлан даалтын нийт хэмжээ нь Сангийн өөрийн хөрөнгийг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.4. Сангийн үйл ажиллагааны зохистой харьцаа Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнд үрэхгүй болсон тохиолдолд хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгийн хэмжээндээ хувь тэнцүүлэн дахин хөрөнгө оруулж өөрийн хөрөнгийн дутууг нөхөх саналыг Сан тавьж болно.

14.5. Энэ хуулийн 14.4-т заасан саналыг өрөнгө оруулагч хүлээж аваагүй бол аль нэг хөрөнгө оруулагч дангаараа, эсхүл хэд хэдэн хөрөнгө оруулагч хамтран хөрөнгийн дутууг нөхөх зөрүүг олгож, зохистой харьцааны үзүүлэлтийг шаардлагатай түвшинд хүргэх арга хэмжээг авч болно.

15 дугаар зүйл. Сангийн санхүүгийн тайлан

15.1. Сан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлан гаргана.

15.2. Сан санхүүгийн тайлангаа жил бүр Санхүүгийн зохицуулах хороо, жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

15.3. Сангийн санхүүгийн тайлан нь тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

16 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны тавих хяналт

16.1. Санхүүгийн зохицуулах хороо Сангийн өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

16.2. Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 16.1-д заасан дүрэм, журмыг батлахдаа жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авна.

ДОЛДУГААР БҮЛЭГ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДУУСГАВАР БОЛОХ

17 дугаар зүйл. Санг татан буулгах

17.1.Санг Иргэний хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу татан буулгана.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1.Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомжонд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч дараах захиргааны хариуцлага ногдуулна:

18.1.1.энэ хуулийн 14.2-т заасныг өрчиж батлан даалт гаргасан бол ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

18.1.2.тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Сангийн зохицуулах хороонд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

18.1.3.Сангийн үйл ажиллагаатай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан тодруулга, мэдээллийг үндэтгэн үзэх шалтгаангүйгээр гаргаж өгөхөөс зайлсхийсэн ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

18.1.4.хяналт, шалгалтад саад учруулсан ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ
